



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”**

**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027

Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,

Цахим шуудан: info@erdenetmc.mn,

Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.10.14 № 67-112-12/6617  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тендер шалгаруулалтыг түдгэлзүүлсэн  
тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Ачааны болон авто ачигчийн дугуй” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102366 дугаартай тендер (НТШ) шалгаруулалтад оролцсон оролцсон “Платиниум их өргөө констракшн” ХХК, “Сүмбэр-Арсай” ХХК Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн яамны 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-т заасны дагуу гомдол гаргасан тул Сангийн яам 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 03/8509 дүгээр албан бичгээр хуулийн 59.6 дахь хэсэгт заасныг үндэслэн гүйцэтгэгч сонгох ажиллагааг 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн болохыг үүгээр мэдэгдье.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН  
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН  
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407034674



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.10.15 № 03/8509

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Төндөр шалгаруулалтыг түдгэлзүүлэх тухай

Танай байгууллагаас зарласан ЭҮТӨҮГ/20240102366 дугаартай “Ачааны болон авто ачигчийн дугуй” нийлүүлэгчийг сонгох төндөр шалгаруулалтад оролцсон “Платиниум их өргөө констракшн” ХХК, “Сүмбэр-Арсай” ХХК-аас тус тус Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төндөр шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам” (цаашид “журам” гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн түдгэлзүүлж байна.

Иймд гомдлыг хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгийг 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Үүнд:

1. Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар;
2. Үнэлгээний хороо байгуулсан шийдвэр;
3. Батлагдсан төндөр шалгаруулалтын баримт бичиг;
4. Оролцогчдын ирүүлсэн төндөр /Төндөр нээх нууц үг/;
5. Төндөрийн нээлтийн тэмдэглэл;
6. Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл;
7. Оролцогч болон бусад байгууллагуудтай харилцсан бичиг;
8. Гэрээ байгуулах эрх олгох, шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр;
9. Захиалагч гомдол хянан шийдвэрлэсэн бол холбогдох шийдвэр;
10. Холбогдох бусад баримт бичиг.

Түүнчлэн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэж, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн төндөрийн баталгааг чөлөөлөхгүй байхыг анхаарна уу.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГАТ Ж. ГАНБАТ



9766016041